



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 4/104

Мандалговь

Мал угаалгын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1, 21.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 07 сарын 22-ны өдрийн А/258 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шимэгчтэх өвчний гаралт, тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор мал угаалгын ажлыг 2021 оны 07 сарын 22-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Малчид, мал бүхий иргэдэд зарыг хүргэж угаалганд мал сүргийг 100% хамруулж, чанартай гүйцэтгэхийг багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

3. Мал угаалгын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, шуурхай үр дүнтэй зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч (Е.Отгонцэцэг), тархвар зүйч эмч (Д.Эрдэнэцэцэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



И.ЭРДЭНЭЦОГ